



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.30 № 01/593
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА
Ж.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Рашиант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Рашиант сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Рашиант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Рашиант сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Рашиант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Рашаант сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Рашаант сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО


Хөвсгөл аймгийн Рашаант сумын Ардчилсан намын
2024-2028 онд дэвшүүлэх мөрийн хөтөлбөр

Нэг. Иргэдийн сэтгэл ханамж, эрх зүйн боловсролд сууринласан төрийн удирдлага

- Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлж, ажлын чанар үр дүнг дээшлүүлнэ.
- “ХОС БИЧИГТЭН-25” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэлний бодлогын зөвлөл, ЕБС-тай хамтран төрийн албан хаагчдын эх хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.
- Бүх шатны төрийн байгууллагууд хөдөөгийн багт хүрч ажиллах малчин иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ.
- Байгууллагын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулж, сургалтын материаллаг бааз, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээж, авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлага, ухамсыг төлөвшүүлж, төрийн байгууллага, иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгон ил тод байдлыг хангана.
- Ажлын үзүүлэлтээрээ эхний 5-т тогтмол үнэлүүлдэг байна.
- “Цахим Монгол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Сумын төр, төсвийн байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт, дотоод аудит хийх ажлыг жилд 1 удаа зохион байгуулах

Хоёр. Хүний хөгжлийн бодлого

- Залуучуудыг хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, залуучуудын хөгжлийн зөвлөл, залуучуудын элчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж тайлагнах
- Цэцэрлэгийн болон бага насны хүүхдүүдэд Монголын түүх, хэл соёл, үндэсний өв, уламжлал ёс заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн иргэн болгох, сургах танин мэдүүлэх талаар боловсролын байгууллагын гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг сайжруулан хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг оновчтой шийдвэрлэн залуучуудын холбоо, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудыг бодлогын түвшинд дэмжиж ажиллана
- Аймаг, орон нутгаас ахмадуудын дунд зохион байгуулж буй урлаг, спортын уралдаан, тэмцээнд ахмадуудын санал санаачилгыг дэмжиж ажиллана.



0000000001

14. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

Гурав. Эрүүл мэндийн зорилт

1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн мэдлэг олгох эрт илрүүлэг зөвлөн туслах үйлчилгээг жил бүр зохион байгуулж иргэдийн эрүүл мэндийн бодлогыг сумын түвшинд цогцоор авч хэрэгжүүлнэ.
2. Суманд дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангах зорилгоор (шүдний эмч, хүүхдийн эмч) ажиллуулах боломж нөхцөлийг судалж хуулийн дагуу боловсон хүчинээр хангах
3. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох олон талт нөлөөллийн ажлыг зохион байгуулах
4. Эрүүл мэндийн төвийн шаардлагатай тоног төхөөрөмжийг шинжлэх иргэдэд анхан шатны өвчлөлийг оношлох нөхцөлийг бүрдүүлнэ

Дөрөв. Боловсролын бодлого


1. Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшилийн үнэлгээг тогтмол хийж, хоногдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Сургууль завсардсан хүүхдийн судалгаа гаргаж боловсролд тэгш хамруулан сургахад хамтран ажиллах
3. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч хамтран ажиллах
4. Хамран сургалтыг нэмэгдүүлж, 5 настай хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулахад багийн Засаг дарга наортай хамтран ажиллана.
5. ЕБС-ын сургуулиудын үдийн цай, хоол, цэцэрлэгийн хүүхдүүдийн цай хоолны үйлчилгээг сайжруулж хүүхдэд шим тэжээл, амин дэмзэр баялаг хоолоор үйлчилж байгаад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллана.

Тав. Биеийн тамир, спорт, урлаг, соёлын бодлого

15. Сум нийтийн биеийн тамирын арга зүйчийн ажлын байрыг тогтмол хангах
16. Уламжлал болсон “Төрийн албан хаагч, 5 багийн өдөрлөг олон төрөлт хэлбэрээр спорт,урлаг”-ийн наадмыг Сумын Засаг даргын нэрэмжит болгон 2 жил тутамд зохион байгуулна.
17. Ажлын байрны дасгал хийж хэвшиж, амьдралын зөв дадалтай болсон айл өрх, албан байгууллагыг шагнаж урамшуулна.
18. Суманд “Үндэсний сурын харваа, шагайн харваа, бөх”-ийн спортыг хөгжүүлэхэд анхаарч ажиллах, дутагдалтай багш дасгалжуулагчтай хамтран ажиллах

Зургаа. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын чиглэлээр-5

19. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэдний үгийг сонсох албан байгууллагад харьяалалгүй иргэдийн санал бодлыг сонсох өдөртэй болгох ажлыг зохион байгуулна.



00000000000?


20. Аж ахуйн нэгж, албан газруудын ХАБ хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах
 21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар түр болон байнгын ажлын байр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн шинэ тогтвортой бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
 22. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
 23. Идэвхтэй ажил хайж байгаа иргэдийг бүртгэн түр болон бүр ажлын байрт зуучлах ажлыг зохион байгуулна.

Долоо.Хөдөө аж ахуй ногоон хөгжлийн бодлого-б

24. Малчдын жилийн турш орлоготой байх боломжийг судлах, туршлага судлах боломжоор хангах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах тусгай хөргүүр бий болгох ажлуудыг шат дараатай авч хэрэгжүүлнэ.
 25. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаа баталгаажуулах тандалт шинжилгээ хийх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж ажиллах, өвчлөл гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээг авч ажиллах.
 26. Сумын малын өсөлтийг бэлчээрийн даацаад холбогдуулан ШУ үндэслэлтэй тооцоог холбогдох байгууллага Эрдэмтдээр хийлгэж бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, олон наст ургамлыг тариалах, ногоон тэжээл тариалах малчин иргэнийг дэмжиж ажиллана
 27. Мал эмнэлэг үржлийн тасаг, мал эмнэлгүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс тавих хяналтыг нэмэгдүүлэх замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, малчдыг мэдээллээр бүрэн хангаж ажиллана.
 28. Суманд малын тэжээлийн үйлдвэр байгуулах, аж ахуйн нэгж иргэнийг бодлогоор дэмжиж ажиллана.
 29. “Тэрбум мод тарих хөдөлгөөн”-ийг эрчимжүүлж сумын төвийн ногоон байгууламж ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх

Найм. Ил тод төсөв, санхүүгийн бодлого

30. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн үнэлгээний хувийг 50%-д хүргэж, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө болон суманд ирж буй аливаа төсөл, хөтөлбөрүүдийг иргэдэд нээлттэй мэдээлпнэ.
 31. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажиллах, төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавин ажиллах
 32. ХАА ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, тайланг хуулийн хугацаанд тайлagnаж хэвших





0005000001-3